



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 17 өдөр

Дугаар A/70

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн засаг даргын 2018 оны A/588 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчин хүлээн авах зориулалтын байр, зочид буудлуудыг зочны бүртгэлийн нэгдсэн цахим системд шилжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга	Т.Энхболд	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд	Д.Ганболд	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Захиргааны хэлтсийн дарга
	С.Цэвээнсүрэн	Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын мэргэжилтэн
	Р.Дуламжав	Олон нийтийн төлөөлөл /БЗД-ын 25 дугаар хорооны иргэн/
Нарийн бичгийн дарга	Л.Одхүү	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

2. Гүйцэтгэгчийг 2018 оны 9 дүгээр сарын 04-ний дотор сонгон шалгаруулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо Т.Энхболд/-д даалгасугай.

3. Тус тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн A/67 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ ДАРГА



Ц.ЭНХТУВШИН

1150530227